

2

ББСБ-ЫН ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГА

Гүйцэтгэсэн: П.Байгалмаа⁴

⁴ СЗХ, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт email: baigalmaa@frc.mn

ХУРААНГУЙ

Өнөөдөр Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн байгууллагын салбарын үйл ажиллагаанд эрх зүйн тааламжтай орчныг бүрдүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх замаар санхүүгийн зуучлалыг хөгжүүлэх, салбарын хөгжлийг олон улсын жишигт нийцүүлэх, хяналтын оновчтой тогтолцоог бий болгох, салбарыг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна.

Мөнгөн гуйвуулга банкаар дамжиж хийгддэг гүйлгээ байсан. Банк бус санхүүгийн байгууллага банканд дахь өөрийн харилцах дансаар дамжуулан эсхүл интернэт, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж бусдын мөнгөн хөрөнгийг гуйвуулах үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлээд даруй 10 гаран жилийн нүүр үзжээ. Энэхүү цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний харилцааны зохицуулалтын талаар тусгайлан гүйцэтгэсэн судалгаа хараахан байхгүй байна.

2023 оны 01 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр 514 Банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 40 ББСБ нь цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Мөнгөн гуйвуулга нь санхүүгийн хүртээмжийг хөнгөвчлөх, ингэснээр хуримтлал, хөрөнгө оруулалт, бизнес эрхлэх, ажлын байр бий болгоход эергээр нөлөөлж байна. Тийм ч учраас улс орнууд мөнгөн гуйвуулгын үйлчилгээг дэмжихийн сацуу үүсэж болзошгүй эрсдэлээс хамгаалах үр дүнтэй зохицуулалтыг бий болгоход анхаардаг.

Иймээс өөрийн болон бусад орны цахим мөнгөн гуйвуулгын чиг хандлага, зохицуулалтын арга хэрэгсэл, туршлага зэргийг судлах нь зүйтэй гэж үзлээ.

Энэхүү судалгааны ажил нь дараах бүтэцтэй. Нэгдүгээрт цахим мөнгөн гуйвуулгын чиг хандлага, Хоёрдугаар бүлэгт олон улсын байгууллагаас боловсруулсан цахим мөнгөн гуйвуулгатай холбоотой зохицуулалт, болзошгүй эрсдэлийн талаар товч толилуулна. Гуравдугаар бүлэгт бусад орны цахим мөнгөн гуйвуулгын зохицуулалт, туршлага, Дөрөвдүгээр бүлэгт зохицуулагч байгууллагын хяналт, зохицуулалт, Тавдугаар бүлэгт Монгол Улсын цахим мөнгөн гуйвуулгын чиг хандлага, зохицуулалтын хүрээг танилцуулах ба сүүлийн бүлэгт судалгааны ажлыг нэгтгэн дүгнэж, санал зөвлөмж дэвшүүлнэ.

JEL ангилал:

Хураангуй:

Энэхүү судалгаанд цахим мөнгөн гуйвуулгын чиг хандлага, өөрийн болон бусад оронд зохицуулалт, туршлага зэргийг хамруулсан.

Түлхүүр үг:

Цахим мөнгөн гуйвуулга, зардал, өглөг


I.	ЦАХИМ МӨНГӨ ГУЙВУУЛГЫН ЧИГ ХАНДЛАГА	44
	1.1. Мөнгө гуйвуулгын урсгал нь хөгжиж буй орнуудын гадаад санхүүжилтийн гол эх үүсвэр хэвээр байна	44
	1.2. Дэлхийн цахим мөнгөн гуйвуулга	47
	1.3. Мөнгөн гуйвуулгын зардал	48
II.	ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ, ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ	49
	2.1. Олон улсын эрх зүйн нийтлэг зохицуулалт	49
	2.2. Цахим мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэл	51
III.	БУСАД ОРНЫ ЦАХИМ МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА	52
	3.1. Улс орнуудад мөрдөж буй эрх зүйн зохицуулалт	52
	3.2. Сонгон судалсан улс оронд үйлдэгдсэн мөнгөн гуйвуулгатай холбоотой сорил, шийдвэрлэлт	54
	3.3. Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний эрх зүйн нийтлэг зохицуулалт	57
IV.	МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭ	60
	4.1. Мөнгөн гуйвуулгын урсгалын чиг хандлага	60
	4.2. Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч ББСБ-ын өнөөгийн байдал	63
	4.3. Монгол Улсын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний зохицуулалтад мөрдөж буй хууль тогтоомж	68
	ДҮГНЭЛТ	70
	САНАЛ ЗӨВЛӨМЖ	71
	ЗУРАГ ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	
	Зураг 1. Телеграф	44
	Зураг 2. Бага, дунд орлоготой орнуудад чиглэсэн мөнгөн гуйвуулга, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламжийн урсгал, 2000–2024f	45 46
	Зураг 3. Хятадыг эс тооцвол бага, дунд орлоготой орнууд руу шилжүүлсэн мөнгө, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламжийн урсгал, 2000–2024f	46
	Зураг 4. Хүлээн авагч бага, дунд орлоготой орнуудын мөнгөн гуйвуулга, 2022 он	46
	Зураг 5. Дэлхийн цахим мөнгөн гуйвуулгын зах зээлийн хэмжээ	47

Зураг 6. 200 ам.доллар илгээхэд мөнгөн гуйвуулгын зардал, 2021–2022	48
Зураг 7. Гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэд	60
Зураг 8. Гадаадад оршин суугаа иргэдийн эх орон руугаа явуулсан мөнгөн шилжүүлэг (ам. доллароор)	61
Зураг 9. Мөнгөн гуйвуулга 2000–2022 он /ДНБ–д эзлэх хувиар/	61
Зураг 10. Мөнгөн гуйвуулгын орлого 2020.I–2023.I	64
Зураг 11. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг /сая төгрөгөөр/	65
Зураг 12. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг ба Нийт өр төлбөр ба эздийн өмчийн хамаарал	66
Зураг 13. МУТС эрсдэлийн үнэлгээний түвшин	67
Хүснэгт 1. Бага, дунд орлоготой бүс нутгуудад мөнгөн гуйвуулгын урсгалын тооцоо, төсөөлөл (тэрбум ам.доллар)	45
Хүснэгт 2. Хувийн гуйвуулга 2023.I /мян ам.доллар/	
Хүснэгт 3. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ	62 64
Хүснэгт 4. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа төрлөөр	
Хүснэгт 5. Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/	64
Хүснэгт 6. Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	64
Хүснэгт 7. Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/	65
Хүснэгт 8. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 2019.I–2023.I /мянган төгрөгөөр/	65 65
Хүснэгт 9. Корреляцийн шинжилгээ	
ХАВСРАЛТ 1.	66 73



I. ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ЧИГ ХАНДЛАГА

ЗУРАГ 1. ТЕЛЕГРАФ



Хамгийн анх мөнгөн гуйвуулгыг Western Union компани 1872 онд Самуэль Морзе бусад зохион бүтээгчдийн хамт бүтээсэн харилцаа холбооны хэрэгсэл болох морзыг ашиглаж үйлдсэн байна.

МЕТАЛЛ МӨНГӨ



1914 онд Western Union компани нь анхны цэнэглэгч зээлийн картыг "Metal Money" нэрээр харилцагчдадаа хүргэсэн.

БОГИНО ДОЛГИОНЫ СҮЛЖЭЭ



1943 онд хот хооронд богино долгионы радио станцууд бий болж улмаар мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч олон тооны байгууллагууд бий болсон гэж үздэг.

1.1. МӨНГӨ ГҮЙВУУЛГЫН УРСГАЛ НЬ ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДЫН ГАДААД САНХҮҮЖИЛТИЙН ГОЛ ЭХ ҮҮСВЭР ХЭВЭЭР БАЙНА

Гадаадад ажиллаж, амьдарч буй иргэдийн мөнгөн гуйвуулга нь улс орнуудын хувьд хөгжлийн амин сүнс болдог.

Мөнгөн гуйвуулгын ихэнх нь албан бус сувгуудаар явагддаг тул мөнгөн гуйвуулгын урсгалын хэмжээг нарийн тооцоолох боломжгүй.

Илгээсэн мөнгөн гуйвуулгын урсгал 2021 онд дэлхийн хэмжээнд бага зэрэг буурч 2022 оны эхнээс удаашрах төлөвтэй болов. Энэ нь улс орнуудад инфляцын түвшин өндөрсөх, валютын ханш буурах, цар тахлын сөрөг нөлөөлөл илрэх, Украины дайн зэргээс эдийн засгийн орчин хүндэрч дэлхийн эдийн засаг удааширч цагаачдын бодит орлого бууруулсантай холбоотой гэж үзсэн.

2022 оны дундуур улс орон цар тахлын үед авч байсан хориг арга хэмжээнүүдээ суллах, чөлөөлөх дэс дараатай арга хэмжээ авснаар бага, дунд орлоготой орнууд руу илгээсэн мөнгөн гуйвуулгын урсгал өмнөх оноос 8 хувиар нэмэгдэж, 647 тэрбум ам.долларт¹ хүрсэн гэж Цагаачлал ба хөгжлийн товч 37-д нийтлэгдсэн. Тухайлбал: Европ болон Төв Ази руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулгын хэмжээ 2022 онд 79 тэрбум ам.долларт хүрч, өмнөх жилийнхээс 19 хувиар өссөн. Үүнд шилжүүлсэн мөнгөн гуйвуулгын дийлэнх нь ОХУ-аас ирсэн

¹ Joint statement by the UN Network on Migration on the occasion of the International Day of Family Remittances

байна. Энэ нь Орос хөрш зэргэлдээ орнууд руу мөнгөн гуйвуулга их хэмжээгээр хийгдсэнтэй холбоотой.

Латин Америк болон Карибын тэнгисийн орнууд руу мөнгөн гуйвуулгын урсгал 11.3 хувиар нэмэгдэж, 2022 онд 145 тэрбум ам.долларт хүрсэн. Үүнд АНУ–д хөдөлмөрийн зах зээл хүчтэй байсан нь 2022 онд мөнгөн гуйвуулгын урсгалд эергээр нөлөөлсөн. Мексик улс руу гэхэд шилжүүлсэн мөнгө 2022 онд 61.1 тэрбум ам.долларт хүрч, 12.9 хувиар өссөн байна.

Дэлхийн банкны хамгийн сүүлийн үеийн

шилжилт хөдөлгөөн ба хөгжлийн товч танилцуулгад мөнгө шилжүүлдэг улс орнуудын цагаачдын ажил эрхлэлт, цалингийн өсөлтийн хязгаарлалт зөөлөрч, эдийн засгийн идэвхжиж эхэлсэн тул 2023 онд бага, дунд орлоготой орнууд руу чиглэсэн мөнгөн гуйвуулгын урсгал 1.4 хувиар өсөж, 656 тэрбум ам.долларт хүрэх ба Дэлхийн хувьд 2023 онд мөнгөн гуйвуулгын урсгал 840 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй бөгөөд 2024 онд мөнгөн гуйвуулгын өсөлт 2.0 хувь болж, орох урсгалыг 18 тэрбум ам.доллараар нэмэгдэнэ (хүснэгт 1) гэж таамагласан.

Хүснэгт 1. Бага, дунд орлоготой бүс нутгуудад мөнгөн гуйвуулгын урсгалын тооцоо, төсөөлөл (тэрбум ам.доллар)


	2016	2017	2018	2019	2020	2021	2022e	2023f
Бага, дунд орлоготой орнууд	435	475	522	548	542	599	647	656
Дэлхий	590	640	695	727	717	791	831	840
Өсөлтийн хувь (хувь)								
Бага, дунд орлоготой орнууд	-1.5	9.3	9.8	5.0	-1.1	10.6	8.0	1.4
Дэлхий	-1.0	8.4	8.6	4.5	-1.4	10.4	5.1	1.1

Эх сурвалж: Дэлхийн банк – KNOMAD-2020.

Тайлбар: e = тооцоо; f = урьдчилсан мэдээ
Мөнгөн гуйвуулга нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламж, багцын

хөрөнгө оруулалтын урсгалтай харьцуулахад гадаад санхүүгийн том эх үүсвэр хэвээр байсаар байна (зураг 1).


Зураг 2. Бага, дунд орлоготой орнуудад чиглэсэн мөнгөн гуйвуулга, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламжийн урсгал, 2000–2024f



Эх сурвалж: Дэлхийн банк–KNOMAD, ОУВС–гийн төлбөрийн тэнцлийн статистик.



Зураг 3. Хятадыг эс тооцвол бага, дунд орлоготой орнууд руу шилжүүлсэн мөнгө, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламжийн урсгал, 2000–2024f



Эх сурвалж: Дэлхийн банк–KNOMAD, ОУВС–гийн төлбөрийн тэнцлийн статистик.

Тэмдэглэл: Remittances–мөнгөн гуйвуулга, FDI = гадаадын шууд хөрөнгө оруулалт; ODA = хөгжлийн албан ёсны тусламж

Энэ зургаас Хятад улсыг түүврээс хасаж харуулсан ч гадаад санхүүжилтийн гол эхүүсвэрт мөнгөн гуйвуулга ихээхэн ач холбогдолтой болох нь тод харагдаж байна (Зураг 2).


Мөнгө гуйвуулга нь эдийн засгийн хувьд урсгал данс болон төсвийн хомсдолыг санхүүжүүлэхэд ач холбогдолтой тул дотоодын нийт бүтээгдэхүүн

(ДНБ)–д ихээхэн хувь эзэлдэг.


168 орны тоон мэдээллээс авч үзвэл ДНБ–д эзлэх 2022 оны дундаж 5.4 хувь байна. Тухайлбал: Тажикстан (ДНБ–ий 51 хувь), Тонга (44 хувь), Ливан (35 хувь), Самоа (34 хувь), Киргизстан (31 хувь) эхний аравт багтжээ (зураг 3).

Зураг 4. Хүлээн авагч бага, дунд орлоготой орнуудын мөнгөн гуйвуулга, 2022 он

а. тэрбум ам.доллар, 2022 он



б. ДНБ–д эзлэх хувь, 2022 он



Эх сурвалж: Дэлхийн банк–KNOMAD; ОУВС–гийн төлбөрийн тэнцлийн статистик.

Товчлол: ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн.

1.2. ДЭЛХИЙН ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГА

Уламжлалт мөнгөн гуйвуулга нь мөнгөө гуйвуулахын тулд заавал биечлэн очих ба холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх, хураамж төлөх гэх мэт цаг болон зардал шаарддаг.

Санхүүгийн байгууллагууд мөнгө гуйвуулгын үйлчилгээндээ цахим шийдлүүдийг эрчимтэй нэвтрүүлж ашигласнаар энэ салбарт өрсөлдөөн нэмэгдэж, шилжүүлгийн зардал буурах боломжууд бүрдэж үйлчлүүлэгчдийг ихээхэн татаж байна.


Сүүлийн жилүүдэд гар утсаар дамжуулан хил дамнасан төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгыг түргэн шуурхай үйлдэх нь улам түгээмэл болж байна. Хөдөлгөөнт холбооны глобал систем

(GSM) холбооны мэдээлснээр гар утасны аппликейшн ашиглаж 2020 онд 12.7 тэрбум ам.долларыг хил дамнасан гуйвуулсан гэжээ.

Түүнчлэн судалгаагаар гар утасны мөнгөн гуйвуулга 2027 он гэхэд дэлхийн цахим мөнгөн гуйвуулгын зах зээлийн 73 гаруй хувийг эзэлнэ гэж таамаглаж байна.

Дэлхийн цахим мөнгөн гуйвуулгын зах зээлийн хэмжээ 2021 онд 17 тэрбум ам.доллараар үнэлэгдсэн бол 2022 онд 19.65 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд 2030 он гэхэд 60.05 тэрбум ам.доллар болж жилийн нийлмэл өсөлтийн хурд (CAGR) 12.29 хувиар өсөх төлөвтэй гэж таамаглажээ.

Зураг 5. Дэлхийн цахим мөнгөн гуйвуулгын зах зээлийн хэмжээ



Урьдчилан тооцооллоор хил дамнасан цахим гүйлгээний хэмжээ, гар утасны төлбөрийн сувгийн хэрэглээ хоёулаа нэмэгдэх төлөвтэй байна.



1.3. МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ЗАРДАЛ


Олон улсын валютын сангаас санхүүгийн цахим шийдлүүдийг нэвтрүүлэх, оролцоог дэмжих замаар мөнгөн гуйвуулгын зардлыг бууруулах арга хэмжээ авахаа амласан. Түүнчлэн мөнгөн гуйвуулгын дэлхийн дундаж өртгийг Их 20-ийн 5 хувь хүртэл, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтод 2030 он гэхэд 3 хувь хүртэл тус тус бууруулна гэжээ.

Дэлхийн банкны мөнгөн гуйвуулгын үнийн мэдээллээр 2022 оны дөрөвдүгээр улиралд бага, дунд орлоготой орнуудад 200 ам.доллар гуйвуулахад дунджаар мөнгөн дүнгийн 6.2 хувьтай тэнцүү зардал гаргадаг гэсэн нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтоос 2 дахин их байгаа юм.

Хөгжиж буй орнуудын бүс нутгуудын дунд дундаж зардал Өмнөд Азид хамгийн бага буюу 4.9 хувь бол Африкийн Саб–Сахарын орнууд хамгийн өндөр буюу 8 хувь байна (Зураг 5).

Банкнүүдын хувьд 2022 оны дөрөвдүгээр улирлын байдлаар мөнгөн гуйвуулахад хамгийн өндөр өртөгтэй суваг хэвээр байгаа ба түүний дундаж зардал 11.7 хувьтай байна². Шуудангийн үйлчилгээний дундаж зардал 6.3 хувь, мөнгөн гуйвуулгын операторынх 5.4 хувь, үүрэн холбооны операторынх 4.5 хувь байна. Мобайл үйл ажиллагаа нь хамгийн хямд үйлчилгээ үзүүлэгч ч нийт гүйлгээний багахан хэсэг буюу 1–ээс бага хувь эзэлдэг.

Зураг 6. 200 ам.доллар илгээхэд мөнгөн гуйвуулгын зардал, 2021–2022



Эх сурвалж: Дэлхийн банкны мөнгөн гуйвуулгын үнийн мэдээллийн сан.

Тайлбар: Улаан тасархай шугам = Тогтвортой хөгжлийн зорилт 3 хувь, EAP = Зүүн Ази, Номхон далай; ECA = Европ ба Төв Ази; LAC= Латин Америк ба Карибын тэнгис; MENA = Ойрх

Дорнод ба Хойд Африк; SAR = Өмнөд Ази; SDG = Тогтвортой хөгжлийн зорилго; SSA = Африкийн Саб–Сахарын орнууд.

² <https://unread.today/c/spotlight-sendmn>

II. ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ, ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

2.1. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ

ББСБ–ын цахим мөнгөн гуйвуулгын эрх зүйн зохицуулалт нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлага, хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг хамгаалах, цахим аюулгүй байдал, гэрээний нөхцөл, хил дамнасан зохицуулалт зэрэг хууль эрх зүйн олон шинж чанарыг агуулсан байдаг. Эдгээр хууль эрх зүйн шаардлагыг дагаж мөрдсөнөөр ББСБ–ууд санхүүгийн системийн аюулгүй байдлаа хангаж, харилцагчдадаа хариуцлагатай, найдвартай үйлчилгээ үзүүлэх, тэднийг болон үйл ажиллагаагаа санхүүгийн болон залилан мэхлэгдэх гэмт хэргээс хамгаалж чадах учир олон улсын байгууллагууд нэгдсэн эрх зүйн зохицуулалт боловсруулан хамтран хэрэгжүүлж байна.



Мөнгө угаах (anti–money laundering (AML)) болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (counter–terrorist financing (CTF)) арга хэмжээний дэлхийн стандартыг тогтоодог Засгийн газар хоорондын байгууллага болох Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (The Financial Action Task Force (FATF) (ФАТФ)) юм.

ФАТФ–аас гаргасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зөвлөмж боловсруулсан. Уг зөвлөмж нь ББСБ санхүүгийн системийг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, мөнгө угаах болон терроризмыг

санхүүжүүлэхтэй тэмцэхэд зориулагдсан бөгөөд тэр дундаа харилцагчаа сайтар нягтлан шалгах, таньж мэдэх, бүртгэл хөтлөх, тайлагнах шаардлагын талаар зааварчилгаа өгснөөр ББСБ–дыг залилан мэхлэгдэх үйлдлээс болон мөнгө угаахаас урьдчилан сэргийлж хамгаалахад тусалдаг.



Цахим мөнгөн гуйвуулгын стандартыг тогтоодог өөр нэг байгууллага бол Олон улсын стандартчиллын байгууллага (the International Organization for Standardization (ISO)) юм. Тус байгууллагаас ISO 20022 стандартуудыг боловсруулсан. Энэ стандарт нь санхүүгийн байгууллагуудын хооронд цахим мессеж солилцох нийтлэг тогтолцоог бүрдүүлдэг бөгөөд мөнгөн гуйвуулга, цахим төлбөрийг найдвартай гүйцэтгэхэд тусалдаг.



Олон улс орон, бүс нутаг хэрэгжиж байгаа Европын холбооны төлбөрийн үйлчилгээний 2 (Payment Services Directive (PSD2)) стандарт юм. PSD2–ын гол зорилго нь:

- (i) Нэгдсэн хяналт, үр ашгийг нэмэр оруулах;
- (ii) шинэ тоглогчдыг оролцуулах замаар төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн өрсөлдөөний талбарыг тогтвортой байдлыг хангах;
- (iii) төлбөр тооцоог илүү найдвартай хийх;



(iv) Европын хэрэглэгчид болон бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах.

Энэ нь ББСБ-аас харилцагчийг таньж мэдэх баталгаажуулах арга хэмжээг дагаж мөрдөх, гүйлгээний мэдээллийг эрх бүхий гуравдагч этгээдтэй хуваалцахыг шаарддаг.



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон Улсын Худалдааны Хуулийн Комисс (United Nations Commission on International Trade Law (UNCITRAL)) 2005 онд ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгатай холбоотой заалтуудыг багтаасан Цахим шилжүүлгийн бүртгэлийн тухай загвар хуулийг³ боловсруулжээ.

Загвар хууль ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг цогцоор нь бүрдүүлсэн. Тус хууль эрх зүйн тодорхой байдлыг хангах, хил дамнансан худалдааг хөнгөвчлөх, цахим шилжүүлэг, тэр дундаа тоон гарын үсгийг мөнгөн гуйвуулгад ашиглах тогтолцоог бүрдүүлэх, хэрэглэгчдийг хамгаалах зорилготой юм.

Тус загвар хуульд тусгасан үндсэн ойлголтуудаас дурдвал:

» **Цахим шилжүүлгийн бүртгэл** – Энэ нь санхүүгийн хөрөнгийг өмчлөх, шилжүүлэхтэй холбоотой мэдээллийг агуулсан цахим бүртгэл юм. Хуулиар цахим бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хамгаалж, шүүх хуралдаанд нотлох баримт болгон ашиглах боломж олгосон.

» **Дамжуулж болох бүртгэлийн системүүд** Цахим мөнгөн гуйвуулах эрх үүсгэх, хадгалах, дамжуулах боломжийг олгодог системүүд юм. Загвар хуулиар дамжуулж болох бүртгэлийн системүүдийг бий болгох, ажиллуулах талаар зааварчилгаа өгч, тэдгээрийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдалд тавигдах шаардлагыг тодорхойлсон.

» **Зуучлагч** – Энэ нь илгээгч болон хүлээн авагчийн хооронд цахимаар мөнгөн шилжүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэгч нь ББСБ юм. Загвар хуульд зуучлагчдыг хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрч, зохицуулах асуудлыг тусгасан бөгөөд тэдний үйл ажиллагаанд тавигдах шаардлага, харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг тодорхойлсон.

» **Зөвшөөрөл ба хэрэгжилт** – Загвар хуульд тоон гарын үсгийг мөнгө гуйвуулах болон холбогдох цахим бүртгэл хийх, түүний дотор цахим шилжүүлгийн бүртгэл, дамжуулж болох мэдээллийг хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрч, мөрдүүлэх талаар тусгасан.

» **Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай**–төлбөр, хураамжийг ил болгох шаардлага, маргаан шийдвэрлэх механизм зэрэг хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой заалтууд тусгажээ.

³ https://uncitral.un.org/en/texts/ecommerce/conventions/electronic_communications
https://unctad.org/system/files/official-document/a68d17_en.pdf

2.2. ЦАХИМ МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ

ББСБ нь цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлснээр дараах болзошгүй эрсдэлтэй тулгарч болох тул сэргийлэх нь зүйтэй. Үүнд:

» **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх:**

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэх мэт хууль бус үйл ажиллагаанд ашиглаж болзошгүй юм. Энэ тохиолдолд ББСБ–нд өндөр торгууль оногдох бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээдэг тул болгоомжлох ёстой.

» **Хэрэглэгчийн эрх ашгийг хохироох:**

ББСБ–ууд цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ авагч хэрэглэгчдийн эрх ашгийг хохироохгүйн тулд үйлчилгээний мэдээллийг ил тод, шударга байлгахын зэрэгцээ шимтгэл, валютын ханшийг тодорхой зааж өгөх ёстой. Энэ нь хэрэглэгчдээс ирэх аливаа гомдол, асуудлыг шийдвэрлэхэд дөхөм болно.

» **Кибер аюулгүй байдал:**

Мөнгө гуйвуулгын үйлчилгээнд цахим технологийг ашиглах нь хакердуулах, мэдээлэл алдагдах боломжтой. Иймд ББСБ нь өөрийн ашиглаж буй систем, өгөгдөл, мөн харилцагчдынхаа хувийн болон санхүүгийн мэдээллийг хамгаалахад зохих арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

» **Эрх зүйн асуудал:** Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд хил дамнасан гүйлгээ хамардаг тул тухайн улс орны зохицуулагч байгууллагуудын харьяаллын асуудал үүсгэх боломжтой. Энэ байдлаас болж ББСБ нь илгээгч болон хүлээн авагч орны аль алиных нь хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой.

» **Зөвшөөрөл ба зохицуулалт:** ББСБ–аас үзүүлж буй цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээндээ тусгай зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг мөрдөх нь ББСБ–уудад нэмэлт зардал, захиргааны дарамт үүсгэж болох ч үйл ажиллагааны тогтвортой байдлаа хангахад тустай.

» **Уламжлалт мөнгөн гуйвуулгын сувгийг тасалдуулах:** Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өсөлт нь уламжлалт мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Учир нь уламжлалт бол бэлэн мөнгөнд суурилсан шилжүүлгийг оператор үйлддэг тул салбарын зохицуулалтаас гадна санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнд нөлөөлж болно гэж үзэж байна.



III. БУСАД ОРНЫ ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА

3.1. УЛС ОРНУУДАД МӨРДӨЖ БҮЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Сонгон судалсан улс орнууд дахь ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээг зохицуулдаг эрх бүхий байгууллага болон эрх зүйн актуудтай танилцъя.

Америкийн Нэгдсэн Улс /АНУ/ – АНУ-д мөнгө шилжүүлэх, төлбөр төлөх болон мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх нь холбооны болон муж улсын хууль тогтоомжийг мөрдөнө.

Холбооны түвшинд гол зохицуулагч байгууллага бол АНУ-ын Сангийн яамны нэг хэсэг болох Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (Financial Crimes Enforcement Network (FinCEN)) юм.

FinCEN нь Банкны нууцын тухай хууль болон холбогдох мөнгө угаахтай тэмцэх зохицуулалтыг мөрдөхийг шаарддаг. Тухайлбал ББСБ-аас сэжигтэй үйл ажиллагааны тайлан тайлагнах, мөнгө угаах хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцагчийг таньж мэдэх гэх мэт болно.

FinCEN-ээс гадна мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ-уудыг хянадаг холбооны бусад зохицуулагч байгууллагууд нь Хэрэглэгчийн санхүүг хамгаалах товчоо (Consumer financial protection bureau (CFPB)), Валютын хяналтын алба, Холбооны хадгаламжийн даатгалын корпорац (FDIC) байна.

Мужийн түвшинд мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ-ууд нь мужийн санхүүгийн зохицуулах агентлагаас тусгай зөвшөөрөл авч, зохицуулалтад хамрагддаг.

ББСБ нь дээр дурдсан хууль тогтоомжоос

гадна Мэдээллийн нууцлалын тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэрээний тухай хууль зэрэг анхаарах ёстой хууль эрх зүйн актууд бий.

Энэтхэг улс – Энэтхэг улсад цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ-уудын зохицуулалтын тогтолцоо бүрдсэн. ББСБ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг дүрэм, хэрэглэгчийн эрхийг хамгаалах журам, мэдээлэл хамгаалах дүрмийг дагаж мөрдөнө.

Харин хил дамнасан мөнгөн гуйвуулга эрхэлдэг ББСБ нь Гадаад валютын удирдлагын тухай хууль болон Энэтхэгийн үнэт цаас, биржийн зөвлөлөөс гаргасан дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллана.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ-ууд зөвшөөрөл авна.

Энэтхэгт мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ-уудыг 2007 онд баталсан Төлбөр тооцооны системийн тухай хуулийн дагуу мөнгөн гуйвуулгын системийн аюулгүй байдал, найдвартай байдал, тогтвортой байдлыг хангуулах чиг үүрэг нь Энэтхэгийн нөөцийн банк (Reserve Bank of India (RBI)) юм. ББСБ-д дараах арга хэмжээ, шаардлагыг хэрэгжүүлж ажиллана:

Үйлчлүүлэгчээ таньж мэдэх хэм хэмжээ:

Үйлчлүүлэгчээ таньж мэдэх удирдамжийн дагуу үйлчлүүлэгчдийнхээ хувийн мэдээлэл, хаягийг баталгаажуулах;

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй

тэмцэх арга хэмжээ: МУТСТ хууль тогтоомжийг дагаж мөрдөх, хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтныг томилох, сэжигтэй гүйлгээний талаар Санхүүгийн тагнуулын байгууллагад мэдээлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх;

Өөрийн хөрөнгийн хүрэлцээнд тавигдах шаардлага:

Санхүүгийн тогтвортой байдлаа хангахын тулд өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хэмжээг хангаж ажиллах; Технологи, аюулгүй байдлын стандартууд; Харилцагчдынхаа гүйлгээний болон мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд зохих технологи, хамгаалалтын арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх механизм:

Үйлчлүүлэгчдийн гомдлыг шийдвэрлэх, шуурхай шийдвэрлэхийн тулд гомдол барагдуулах механизмтай байх.

Филиппин улс – Филиппин улсад цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ–ууд тусгай зөвшөөрөл авах ба тэдгээрийн харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулдаг.

- 1993 онд батлагдсан Төв банкны тухай хууль (Бүгд найрамдах улсын хууль №7653) – Энэ хуулиар Филиппиний мөнгөний төв байгууллага болох Филиппиний Төв банк (Bangko Sentral ng Pilipinas (BSP)) нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–уудыг зохицуулах үүрэгтэй.
- 2000 онд батлагдсан Банкны ерөнхий хууль (Бүгд найрамдах улсын №8791 дүгээр хууль) Энэ хууль нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх ББСБ–д тавигдах шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг

зохицуулна. Энэ хуулийн дагуу ББСБ мөнгө гуйвуулгын үйлчилгээ эрхлэхийн тулд тусгай зөвшөөрөл авах ёстой.

- 2001 онд батлагдсан Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль (Бүгд найрамдах улсын хууль №9160)–аар Филиппиний санхүүгийн системийг мөнгө угаах үйл ажиллагаанд ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм. Энэ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–ыг харилцагчийг таних, баталгаажуулах журмыг дагаж мөрдөх, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэх, гүйлгээний бүртгэл хөтлөхийг шаардсан.
- Валютын журам (BSP Circular №1041) – Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–уудын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмыг тусгасан. Үүнд лиценз, капиталжуулалт, тайлагналын шаардлага, эрсдэлийн удирдлага зэргийг хамруулсан.

Мөн ББСБ нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах журам, мэдээлэл хамгаалах дүрмийг тус тус дагаж мөрдөнө.

Мексик улс – Мексик улс цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч ББСБ–ын үйл ажиллагааг 2018 оны 09 дүгээр сарын 10–ны өдөр хүчин төгөлдөр болсон Мексикийн Санхүүгийн технологийн байгууллагын тухай хууль (Ley de Instituciones de Tecnologia Financiera буюу Финтекийн тухай хууль)–аар зохицуулдаг.

Уг хуулийн дагуу ББСБ нь санхүүгийн үйл ажиллагаа явуулахын тулд Үндэсний банк, Үнэт цаасны хороо (Comisión Nacional Bancaria y de Valores буюу “CNBV”)–ноос зөвшөөрөл авах ёстой. Мөн капиталжуулалт, засаглал, эрсдэлийн удирдлага, хэрэглэгчийн эрхийг



хамгаалахтай холбоотой зохицуулалтын тусгай зөвшөөрлийн шаардлагыг дагаж мөрдөнө.

Мексик улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ нь дээр дурдсан хуулиас гадна дараах эрх зүйн актыг дагаж мөрдөх ёстой.

- Гадаад валютын гүйлгээ, гадаад валют худалдах, худалдан авах үйл ажиллагааг зохицуулдаг Валютын тухай хууль (Ley del Mercado de Valores).
- Мөнгө угаахын эсрэг хууль (Ley Anti-Lavado de Dinero). Энэ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг тогтоодог.
- Төлбөрийн системийн тухай хууль (Ley de Sistemas de Pagos). Уг хуулиар ББСБ-уудыг төлбөрийн системийн операторын гишүүн байхыг шаарддаг.
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (Ley Federal de Protección al

Consumidor). Энэ нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах зохицуулалтыг бий болгож, ББСБ-аас харилцагчаа үйлчилгээ, төлбөрийн талаар тодорхой, ил тод мэдээллээр хангахыг шаарддаг.

Мексик дэх ББСБ-ууд мөн эдгээр зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөхийн тулд CNBV-ийн байнгын хяналт дор үйл ажиллагаагаа эрхэлнэ.

Дээр дурдсан улс орнуудад цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ-уудын харилцааг зохицуулах тогтолцоо нь өөр өөр байдаг ч нийтлэг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг зохицуулалт, хэрэглэгчийн эрхийг болон мэдээлэл хамгаалах зэрэг зохицуулалтууд нь ижил төстэй байна. ББСБ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүүгийн зах зээл, өөрийн байгууллагын болон харилцагчийн нэр хүндэд хохирол учруулахгүйн тулд үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэр бүртээ зохицуулалтын шаардлагыг бүрэн дагаж мөрдөнө.

3.2. СОНГОН СУДАЛСАН УЛС ОРОНД ҮЙЛДЭГДСЭН МӨНГӨН ГҮЙВУУЛГАТАЙ ХОЛБООТОЙ СОРИЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Сонгон судалсан улс орнуудад мөнгө гуйвуулгын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг авч үзвэл:

Америкийн Нэгдсэн Улс:

Western Union: 2017 онд Western Union нь залилан мэхлэх, мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадаагүйн улмаас АНУ-ын Хууль зүйн яам (DOJ) болон Холбооны Худалдааны Комисс (FTC)-ын тооцоогоор 586

сая ам.долларын торгууль төлөх болсон. Тус компани нь хүн хууль бусаар хил давуулсан, гэмт хэрэгтнүүдийг хууль бусаар мөнгө шилжүүлсэн, залилан мэхлэгчид мөнгө гуйвуулгын үйлчилгээг ашиглан хэрэглэгчдийг залилан мэхлэх боломж олгосон гэдгээ хүлээн зөвшөөрсөн⁴.

MoneyGram: АНУ-ын Хууль зүйн яам, 2012 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр мөнгө угаахтай тэмцэх үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлээгүй,

⁴ "Western Union to Pay \$586 Million Over Fraudulent Money Transfers," The New York Times, January 19, 2017

утсаар маркетингийн схемд мөнгө шилжүүлэх үйлчилгээгээ ашиглан хэрэглэгчдийг залилан мэхлэх боломж олгосон гэх гэм буруугаа хүлээсэн тул 100 сая ам.доллар төлүүлэх арга хэмжээ авсан⁵.

Liberty Reserve: Артур Будовский дэлхийн өнцөг булан бүрд гэмт хэрэгтнүүдийн хууль бус орлого /тухайлбал хөрөнгө оруулалтын луйвар, зээлийн картын луйвар, хувийн мэдээллийг хулгайлах, компьютерыг хакердсанаас олсон орлогыг цуглуулах, түгээх, хадгалах, угаах зорилгоор ашигладаг мөнгө дамжуулах гол үйлчилгээг/оос олон зуун сая ам.доллар угаасан далд ертөнцийн онлайн төлбөрийн кибер банкны систем болох Liberty Reserve-г 2006 онд үүсгэн байгуулж, ажиллуулж байсан. 2013 онд үүсгэн байгуулагч 42 настай Будовскийг Испанид баривчилж, АНУ-д шилжүүлэн өгчээ. 2013 оны тавдугаар сард АНУ-ын засгийн газар Liberty Reserve-ийг хаахаас өмнө дэлхий даяар 5 сая гаруй хэрэглэгчийн бүртгэлтэй үүний дотор АНУ дахь хэрэглэгчидтэй холбоотой 600,000 гаруй данс байсан бөгөөд сая сая гүйлгээг хийгдэж байжээ. Артур Будовский дижитал валютын бизнесээрээ дамжуулан 250 сая ам.долларыг гэмт хэргийн шинжтэй угаасан гэм буруугаа хүлээв. Иймд түүнд 2016 оны тавдугаар сарын 06-ны өдөр ял оноосон. Тус компанийг мөнгө угаах, хувийн мэдээлэл хулгайлах, хар тамхины наймаа зэрэг хууль бус гүйлгээнд 6 тэрбум гаруй ам.долларын гүйлгээ хийсэн гэж буруутгасан⁶.

Энэтхэг улс:

Payworld: 2019 онд дижитал төлбөрийн платформ Payworld нь Энэтхэгийн гадаад валютын зохицуулалтыг зөрчин Энэтхэгээс Дубай руу зөвшөөрөлгүй хууль бус мөнгөн гуйвуулга үйлдэхэд тусалсан гэж буруутгагдсан. Тус компани буруутай үйлдлээ үгүйсгэж байгаа⁷.

Vodafone M-Pesa: 2019 онд гар утасны мөнгө шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгч Vodafone M-Pesa-г Энэтхэгийн Нөөцийн банк (RBI) хэрэглэгчээ таних болон мөнгө угаахтай тэмцэх журам зөрчсөн гэж торгууль ногдуулсан. RBI нь Vodafone M-Pesa-г үйлчлүүлэгчийг зохих ёсоор шалгаж, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлээгүй болохыг тогтоож 3.05 сая рупи (ойролцоогоор 410,000 ам.доллар)-р торгожээ⁸.

Weizmann Forex: RBI -аас 2019 онд валютын болон мөнгө гуйвуулгын Weizmann Forex компанийг мөнгө угаахтай тэмцэх журмын зохих хяналтыг хэрэгжүүлж, үйлчлүүлэгчдэд зохих шалгалт хийж чадаагүй болохыг нь тогтоож 3 сая рупи (ойролцоогоор 400,000 ам.доллар)-ийн торгууль ногдуулсан⁹.

Филиппин улс:

Филрем: 2016 онд мөнгө гуйвуулгын үйлчилгээ эрхлэгч Philrem компанийг Бангладешийн банкнаас хулгайлагдсан 81 сая ам.долларыг угаасан хэрэгт холбогдуулсан. Уг хөрөнгийг Philrem болон хэд хэдэн банк, мөнгөн

⁵ "MoneyGram to Pay \$100 Million for Fraudulent Money Transfers," The New York Times, November 9, 2012

⁶ "Liberty Reserve Digital Currency Founder Pleads Guilty to Laundering \$250 Million," U.S. Department of Justice, October 31, 2014

⁷ "ED arrests Payworld director in money laundering case," The Economic Times, October 16, 2019

⁸ "Vodafone M-Pesa fined ₹3 crore by RBI for AML non-compliance," Livemint, October 10, 2019

⁹ "RBI imposes Rs 3 crore penalty on Weizmann Forex for AML violations," The Economic Times, December 20, 2019



гуйвуулгын компаниудаар дамжуулан Филиппин рүү шилжүүлж, дараа нь казиногоор дамжуулан угаасан байна. Филиппиний засгийн газар Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулийг зөрчсөн Philrem компанийн эзэд болон удирдах ажилтнуудын эсрэг эрүүгийн хэрэг үүсгэсэн¹⁰.

RCBC: Мөнгө угаах гэмт хэрэгт Филиппиний Ризал Арилжааны Банкны Корпорац (RCBC) мөн холбоотой байсан. Иймд RCBC-г Филиппиний төв банкнаас хулгайлсан мөнгийг хууль бусаар шилжүүлэхээс сэргийлээгүй гэсэн үндэслэлээр торгууль ногдуулжээ. Мөн RCBC-ийн хэд хэдэн удирдлагуудыг мөнгө угаасан, банкны хууль зөрчсөн хэргээр буруутгасан¹¹.

I-Remit: 2018 онд мөнгө гуйвуулгын I-Remit компанийг мөнгө угаахтай тэмцэх журмыг дагаж мөрдөөгүйн гэж Филиппиний төв банк торгууль ногдуулсан. Төв банк I-Remit нь мөнгө угаахын эсрэг хяналт хангалтгүй, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлээгүй болохыг тогтоожээ. Тус компанид 5 сая Филиппиний песо (олон улсын код PHP) (ойролцоогоор 100,000 ам.доллар)-ын торгууль ногдуулав¹².

Мексик улс:

Мексикт гарсан ББСБ-ын мөнгө гуйвуулгатай холбоотой гэмт хэргийн үйлдэл бол Вестерн Юнион /Western Union/ компани юм.

2018 онд Мексикийн засгийн газраас Вестерн Юнион компанийн мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэхэд шалгалт гүйцэтгэсэн.

Мөрдөн байцаалтын явцад Вестерн Юнион компани нь компани нь мөнгө угаахын эсрэг зохих хяналт, бодлого хэрэгжүүлээгүйн улмаас хууль бус үйл ажиллагаа, тухайлбал утсаар залилан мэхлэх, мөнгө угаах зэрэг хууль бус үйлдлүүдэд тус дөхөм үзүүлж, агентууддаа зохих шалгалт хийлгүйгээр, сэжигтэй үйлдлүүдийг мэдээлэхгүйгээр гүйлгээ хийх боломж олгосон болохыг тогтоосон. Вестерн Юнион компанийг мөнгө угаах, утасны залилангаас урьдчилан сэргийлж чадаагүй гэж 60 сая ам.долларын торгууль ногдуулсан.

Дээр дурдсан хэргүүд нь мөнгөн гуйвуулгын салбарт хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэхийн тулд хэрэглэгчээ таньж мэдэх болон мөнгө угаахын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэхийн чухлыг онцолж, холбогдох хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд өндөр торгууль, хуулийн хариуцлага хүлээлгэдэг болохыг илтгэж байна.

¹⁰ "Philippines Charges Four Over Bangladesh Bank Heist," Reuters, March 15, 2016

¹¹ "Ex-RCBC manager convicted of money laundering," ABS-CBN News, January 10, 2020

¹² "I-Remit pays P5-M fine for AMLC violations," Manila Bulletin, May 7, 2018

3.3. ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ

Судалгаанд хамрагдсан улсуудын хувьд цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа бөгөөд харилцагчдадаа санал болгодог санхүүгийн бүтээгдэхүүн юм.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ–дын үйл ажиллагаанд байнгын хяналт нь аливаа асуудлыг томоохон асуудал болохоос өмнө илрүүлж, шийдвэрлэхэд туслах бөгөөд хяналт, зохицуулалт нь ББСБ–ын үйл ажиллагааг аюулгүй, ил тод байлгах, санхүүгийн системийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хангах, хэрэглэгчдийг хамгаалахад чухал ач холбогдолтой.

Хяналтад ихэвчлэн ББСБ–ын мөнгөн гуйвуулгын харилцааг зохицуулах холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэх, эрсдэл тодорхойлох, удирдах, үүссэн аливаа маргаан, гомдлыг шийдвэрлэх зэрэг асуудлууд багтана.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ–дад тавих хяналтыг тухайн ББСБ–ын үйл ажиллагаа явуулж буй тухайн улсын холбогдох төрийн зохицуулагч байгууллага гүйцэтгэдэг.

Зохицуулагч байгууллага нь ББСБ–ын үйл ажиллагаанд газар дээр нь хэсэгчлэн болон бүрэн хэмжээний хяналт шалгалт хийх, зайнаас ирүүлсэн санхүүгийн тайлан, баримт бичигтэй танилцаж байнгын хяналт тавьж ажилладаг.

Зохицуулагч байгууллага нь ББСБ–ын хэрэглэгчийн эрхийг хамгаалах, мэдээллийн хамгаалалт, эрсдэлийг удирдах хяналт, мөнгө угаах болон терроризмтой тэмцэх арга хэмжээ, харилцагчийн таньж мэдэх, гүйлгээний

хяналтын систем зэргийг үнэлж болно.

Нийтлэг ажиглагдсан зохицуулалтын хувьд мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор харилцагчийг таньж мэдэх, мөнгөн хөрөнгийн гарал үүслийг тодорхойлохтой холбоотой шаардлагуудыг нэлээд тавьдаг байна.

Мөн зохицуулагч байгууллага ББСБ–ын хууль бус үйл ажиллагааг илрүүлж, шийдвэрлэхийн тулд холбогдох хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллаж болно.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ–ын үзүүлж буй мөнгөн гуйвуулгын үйлчилгээг улс орон, харьяаллаас хамаарч зохицуулалт нь өөр өөр байж болох ч ерөнхийдөө дараах нийтлэг шинжийг агуулсан. Үүнд:

- » **Зохицуулалтын нийцэл** – ББСБ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон санхүүгийн үйлчилгээ, мөнгөн гуйвуулгатай холбоотой бүхий л холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой. Эдгээр журамд үйлчлүүлэгчийг таних, баталгаажуулах, гүйлгээг хянах, сэжигтэй үйл ажиллагааг мэдээлэх зэрэг багтана.
- » **Лиценз ба бүртгэл** – Олон оронд цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ нь тусгай зөвшөөрөл авах эсвэл холбогдох зохицуулах байгууллагад бүртгүүлэх шаардлагатай. Уг эрх мэдэлд төв банк, санхүүгийн зохицуулах байгууллага эсвэл бусад төрийн байгууллагууд багтаж болно.
- » **Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж



буй ББСБ нь үйлчилгээнийхээ хураамж, валютын ханш болон бусад нөхцөл, болзлыг ил тод болгох, хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийг дагаж мөрдөнө. ББСБ-аас гүйлгээтэй холбоотой асуудалтай тулгарсан харилцагчдад буцаан олголт эсвэл нөхөн төлбөр олгох ёстой.

- » **Мэдээллийн нууцлал** – ББСБ нь хэрэглэгчийн мэдээллийг найдвартай, нууцлалтай байлгах үүднээс мэдээллийн хамгаалалт, нууцлалын хуулийг чанд дагаж мөрдөнө.
- » **Гэрээний үүрэг** – ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь ББСБ болон мөнгө илгээгч, хүлээн авагчийн хооронд байгуулсан гэрээ байж болно. Эдгээр гэрээний нөхцөл, болзол нь хууль ёсны дагуу хүчин төгөлдөр байх ёстой. Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүсэх маргаан шийдвэрлэх үйл явц нь тухайн ББСБ-ын үйл ажиллагаа явуулж буй харьяалал, тухайн гүйлгээний тодорхой нөхцөл, ББСБ болон түүний харилцагчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөлөөс хамаарна. ББСБ-ууд маргаанаас зайлсхийх болон шийдвэрлэхэд чухал алхам бол холбогдох зохицуулалтын шаардлагуудыг дагаж мөрдөж, гэрээний нөхцөлүүд нь тодорхой, биелэгдэхээр байх явдал юм. ББСБ-ын маргааны шийдвэрлэлтийн нийтлэг байдлыг авч үзвэл:
 - **Холбогдох хууль** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээг зохицуулах холбогдох хууль тогтоомж нь ББСБ болон түүний харилцагчдын харьяаллаас хамаарч өөр өөр байж болно. Ихэнх тохиолдолд ББСБ-ын бүртгэлтэй эсвэл үндсэн үйл ажиллагаа

явуулдаг харьяаллын хууль үйлчилнэ. Мөн ББСБ болон харилцагчийн хооронд байгуулсан гэрээнд холбогдох хуулийг зааж өгч болно.

- **Маргаан шийдвэрлэх харьяалал** – ББСБ болон түүний харилцагчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөлөөс хамааран маргаан хянан шийдвэрлэнэ. Ихэнх тохиолдолд гэрээнд тодорхой шүүх, арбитр гэх мэт маргааныг шийдвэрлэх харьяаллыг зааж өгч болно. Эсвэл ББСБ-ын бүртгэлтэй буюу үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг харьяаллынх нь дагуу маргаан хянан шийдвэрлэх харьяаллыг тогтоож болно.
- **Арбитр** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний олон гэрээнд арбитрын заалтууд багтдаг бөгөөд маргааныг шүүхээр бус арбитрын шүүхээр шийдвэрлэхийг шаарддаг. Энэ нь маргааныг шийдвэрлэх илүү үр ашигтай, зардал багатай арга замыг бий болгож болно.
- **Зуучлах** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний гэрээнд маргааныг зуучлагчаар дамжуулан шийдвэрлэх шаардлагатай зуучлалын заалтууд багтаж болно. Эвлэрүүлэн зуучлах нь маргааныг шийдвэрлэхэд бага зэрэг зөрчилдөөнтэй, илүү хамтран ажиллах боломжийг олгодог.
- **Зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ нь маргаан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөнө. Үүнд гомдлыг шийдвэрлэх үйл явц, тухайлбал, томилсон гомдол

хариуцсан ажилтантай байх ба тэрбээр үйлчлүүлэгчийн гаргасан гомдлыг хянах, гомдол шийдвэрлэх үйл явцад хамаарах алхмуудыг зааж, мэдээлэл өгөх зэрэг шаардлагууд багтаж болно.

» **Хил дамнансан зохицуулалт** – Хил дамнансан гүйлгээг хамарсан цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь гадаад валют болон татварын зохицуулалт, орон нутгийн хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

» **Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тавих** – Зохицуулагч байгууллага цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ–д зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоож болно. Энэхүү зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нь ББСБ–ын санхүүгийн тогтвортой байдал, тогтвортой байдлыг үнэлэх, үйл ажиллагаагаа аюулгүй, найдвартай эрхлэхэд ашигладаг санхүүгийн хэмжүүр болно.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хэмжээ нь харьяалал болон зохицуулах байгууллагаас хамаарч өөр өөр байж болно. Гэсэн хэдий ч хэрэглэж болох нийтлэг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг дурдъя. Үүнд:

» **Хөрөнгийн хүрэлцээний харьцаа (Capital Adequacy Ratio (CAR))** – Энэ нь ББСБ–ын алдагдлыг шингээх чадварыг илэрхийлдэг үзүүлэлт юм. ББСБ–ын дүрмийн санг эрсдэлд тооцсон хөрөнгөнд нь хувааж тооцдог. CAR өндөр байх тусам ББСБ нь санхүүгийн хувьд илүү найдвартай гэж үзэж болно.

– **Хөрвөх чадварын харьцаа (Liquidity Ratio)** – Энэ нь ББСБ–ын богино хугацаанд үүргээ биелүүлэх чадварыг хэмждэг. ББСБ–ын хөрвөх чадвартай

хөрөнгийг богино хугацаат өр төлбөрт нь хувааж тооцдог. Хөрвөх чадварын харьцаа өндөр байх нь ББСБ үүргээ биелүүлэх чадвартайг харуулна.

– **Хөшүүргийн харьцаа (Leverage Ratio)**

– Энэ нь ББСБ–ын өөрийн хөрөнгөтэй харьцуулахад эрсдэлд өртөх нийт хэмжээг хэмждэг. ББСБ–ын нийт хөрөнгийг өөрийн хөрөнгөд хуваах замаар тооцно. Хөшүүргийн харьцаа бага байх тусам ББСБ–ыг санхүүгийн хувьд илүү найдвартай гэж үзнэ.

– **Хөрөнгийн чанарын харьцаа (Asset Quality Ratio)** – Энэ нь ББСБ–ын хөрөнгөтэй холбоотой эрсдэлийг удирдах, хянах чадварыг хэмждэг.

ББСБ–ын чанаргүй зээлийг нийт зээлд нь хувааж тооцдог. Энэ харьцаа бага байх тусам ББСБ–ын хөрөнгийн чанар сайжирна.

– **Зохицуулалтын тайлан, хяналт** – ББСБ–ууд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтээ ханган ажиллаж байгаа эсэхэд зохицуулагч байгууллагууд байнгын хяналт тавьж, шалгалт хийх бөгөөд ББСБ нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээгээ зохицуулагч байгууллагад тогтмол хүргүүлж, аудит хийлгэх ёстой.

Ерөнхийдөө цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ нь хэрэглэгчдийг хамгаалах, санхүүгийн системийн нэгдмэл байдлыг хангахад чиглэсэн хууль эрх зүйн хүрээнд ажиллана.




IV. МОНГОЛ УЛСЫН МӨНГӨН ГУЙВУУЛГЫН УРСГАЛЫН ЧИГ ХАНДЛАГА, ББСБ-ЫН МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭ

4.1. МӨНГӨН ГУЙВУУЛГЫН УРСГАЛЫН ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улсын Гадаад харилцааны яамны албан арьдарч байгаагаас 158 мянган иргэд буюу 80.1 бус мэдээллээр 2019 оны байдлаар нийт 197 хувь нь АНУ, Европын холбооны улсууд, БНСУ, мянган иргэн гадаад улс орнуудад ажиллаж, Япон, Австрали улсад байна¹³.

Зураг 7. Гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэд



Эх сурвалж: <http://hmc.mn/medee/v/32>

2020 оны байдлаар гадаадад Монгол Улсын 130 мянга орчим иргэн ажиллаж амьдарч, 25 мянга гаруй монгол оюутан суралцаж байна.


Тэдний эх орон руугаа шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 2017 оноос өмнө харьцангуй тогтвортой байв. Монгол Улс 2017 онд 269 сая ам.доллартой тэнцэх хэмжээний мөнгөн гуйвуулга хүлээн авсан.

Харин энэ тоо 2018, 2019 онд тус тус 440 сая, 561 сая ам.долларт хүрч огцом өссөн ч цар тахалтай холбоотой дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлын улмаас 2020 онд 549 сая ам.доллар болж буурсан¹⁴.

¹³ <http://hmc.mn/medee/v/32>

¹⁴ Дэлхийн банк, 2020. <https://data.worldbank.org/indicator/BX.TRF.PWKR.CD.DT?locations=MN>

Зураг 8. Гадаадад оршин суугаа иргэдийн эх орон руугаа явуулсан мөнгөн шилжүүлэг (ам.доллаароор)




Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/BX.TRF.PWKR.CD.DT?locations=MN>

Гадаадад оршин суугаа иргэдийн эх орныхоо эдийн засагт оруулах хувь нэмрийг илэрхийлдэг мөнгөн урсгал сүүлийн арав гаран жилд ДНБ-ний 2–4 орчим хувийн хооронд хэлбэлзэж байна.

Монгол Улсын эдийн засаг өсөлттэй байсан 2011 онд гадаадад ажиллаж амьдарч байсан монголчуудын мөнгөн гуйвуулгын урсгал ДНБ-ий 2.8 хувьд байсан. Харин 2012–2016 онд мөнгөн гуйвуулга харьцангуй тогтвортой болсон¹⁵.

Зураг 9. Мөнгөн гуйвуулга 2000–2022 он /ДНБ–д эзлэх хувиар/



Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/BX.TRF.PWKR.DT.GD.ZS?locations=MN>

¹⁵ Монгол Улсын хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ 2018



Дэлхийн Банкны хөгжлийн шалгуур үзүүлэлтэд Монгол Улс 2020 онд ДНБ-ий 4.1 хувьтай тэнцэх хэмжээний гуйвуулгыг гадаадад амьдарч буй ажиллагсдаас хүлээж авсан¹⁶. Энэ үзүүлэлтээр хамгийн их валют хүлээн авдаг улс орны жагсаалтын 50 дугаар байрт бичигджээ¹⁷.

Харин 2022 онд ДНБ-ий 2.4 хувьтай тэнцэх хэмжээний гуйвуулгыг хүлээн авсан байна.

Монголбанкнаас эрхлэн гаргасан Гадаад секторын статистик 2023 оны I дүгээр улирлын тоймд Монгол Улс 154 сая ам.долларыг хувийн гуйвуулга, хандив тусламж болон бусад

хоёрдогч орлого хэлбэрээр хүлээн авч, 19 сая ам.долларын зардлыг гадагш шилжүүлсэн. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал орлого 3 хувиар, зардал 12 хувиар тус тус буурсан гэжээ.

Гадаадад ажиллаж, амьдарч буй монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулга өмнөх оноос 21 хувиар, гадаад руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 7 хувиар тус тус буурсан, цэвэр дүнгээр 12 сая ам.долларын орлого хүлээн авсан байна.

Хүснэгт 2. Хувийн гуйвуулга 2023.I /мян ам.доллар/

Үзүүлэлт	Хүлээн авсан		Шилжүүлсэн	
	Дүн	Хувь	Дүн	Хувь
Солонгос	10,418	35%	3,624	21%
АНУ	8,581	29%	4,432	26%
БНХАУ	49	0%	446	3%
Хонконг	197	1%	256	1%
Их Британи	598	2%	670	4%
ОХУ	28	0%	-	0%
Сингапур	2,522	9%	437	3%
Швейцар	560	2%	199	1%
Герман	2,609	9%	916	5%
Япон	175	1%	634	4%
Бусад	3,865	13%	5,739	33%
НИЙТ	29,603	100%	17,354	100%

Эх үүсвэр: Гадаад секторын статистик /2023 оны I дүгээр улирал/

Монгол Улсаас мөнгө гуйвуулга илгээх, хүлээн авах зардлын талаарх нэгдсэн мэдээллийн сан одоогоор байхгүй байна. Ихэнх банкууд өөрийн цахим хуудсанд Монголоос мөнгө шилжүүлэхтэй холбоотой шимтгэл хураамжийн мэдээллийг байршуулсан байдаг. Жишээлбэл 200 ам.доллартой тэнцэх хэмжээний гүйлгээ

хийхэд корреспондент банкны үйлчилгээтэй холбоотойгоор үнийн дүнгийн 18–28 хувийг шимтгэлд авдаг.

Олон улсын мөнгөн гуйвуулгын операторуудын сүлжээгээр дамжуулж хийх тохиолдолд гүйлгээний хураамж 6–8 хувийн хооронд хэлбэлзэж байна.

Харин ББСБ мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд нийт дүнгийн 1.0–2.5 хувьтай тэнцэх хэмжээний шимтгэл авч байна.

¹⁶ <https://tradingeconomics.com/mongolia/remittance-in-flows-to-gdp-percent-wb-data.html>

¹⁷ <https://unread.today/c/insight-international-transfer-1>;
<https://ikon.mn/n/1xtm>

4.2. ЦАХИМ МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ББСБ–ЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2023 оны I дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй 514 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 40 ББСБ нь цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Ийнхүү мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ББСБ–ууд эрхэлснээр харилцагчдадаа Арилжааны банкны SWIFT–ээр дамжуулан шилжүүлэг хийхэд 100 ам.доллар эсхүл 1000 ам.доллар ч байсан 35–60 ам.долларын шимтгэл авдаг, цаг хугацааны хувьд 2–7 хоног зарцуулах ба өөрийн биеэр баримт бичиг авч очих, анкет бөглөх, хүлээн авагч нь мөн өөрийн биеэр банкин дээр очиж хүлээн авах, бэлнээр авахад шимтгэл төлөх зэрэг асуудлыг хөнгөвчилж, үйлчилгээг хүртээмжтэй болгосон.

Өнөөдөр жишээлбэл: SendMN–ийг санхүүгийн апп ашиглаж, дэлхийн 170 гаруй улсын 435 мянга гаруй цэгээс мөнгө шилжүүлж, хүлээн авч байна. Мөн Өмнөд Солонгос, Япон, Орос, Хятад, Зүүн өмнөд Азийн нийт арван улс руу харилцагчид өөрийн гар утасны аппликейшн ашиглан “шууд” мөнгөн гуйвуулга хийх боломжтой болсон.

Төв Шууданд байрлах “Ард кредит” ББСБ–ын салбараас “Монгол шуудан” ХК–ийн салбаруудаар дамжуулан дэлхийн 160 гаруй орны шуудангийн 400 мянган гаруй салбараар дамжуулан мөнгө хүлээн авах, гуйвуулга хийж байна.

“Сайн финанс” ББСБ гэхэд олон улсын мөнгөн гуйвуулгыг гар утасны апп болон цахим хуудас ашиглан хийж байна.

ББСБ–уудын олон улсад хийгдэх мөнгөн гуйвуулгын шимтгэлийн хэмжээ тухайлбал 300 ам.долларт 4 ам.доллар, 500.0 ам.долларт 5.0 ам.доллар ба ерөнхийдөө шилжүүлэх мөнгөн дүнгийн 1.0–2.5 хувь хооронд байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос олон нийтэд мэдээлдэг ББСБ–уудын 2023 оны I улирлын санхүүгийн тайлан нэгтгэл¹⁸–ийн танилцуулгад санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй ББСБ өмнөх оны мөн үеэс 2 ББСБ–аар нэмэгджээ.

¹⁸ ББСБ–уудын 2022 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

**Хүснэгт 3.** Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ¹⁹

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2022-I	2023-I	тоо	хувь
	Нийт ББСБ-ын тоо	529	514	(15)	-2.8%
1	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	38	40	2	5.3%

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй 40 ББСБ нь газар зүйн байршлын хувьд Улаанбаатар хотод оршиж байна.

Хүснэгт 4. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа төрлөөр²⁰


№	ТЗ-тэй ББСБ-ын тоо	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
1	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	40	21	27	13	-	39	1	3	37	1

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх ББСБ-уудын мөнгөн гуйвуулгын орлого өмнөх оны мөн үеэс 95.4 хувиар өсөж 1,037,080.4 сая төгрөгт хүрчээ.

Хүснэгт 5. Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/

ОРЛОГО	2021	2022	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Мөнгөн гуйвуулга	530.6	1,037.1	0.4%	506,441.1	95.4%

Мөнгөн гуйвуулгын орлогыг сүүлийн 4 жилийн I улирлаар харуулбал дараах байдалтай байна.

Зураг 10. Мөнгөн гуйвуулгын орлого 2020.I-2023.I

¹⁹ ББСБ-уудын 2022 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

²⁰ ББСБ-уудын 2022 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

Мөнгөн гуйвуулгын орлогыг задалж харуулбал:

Хүснэгт 6. Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Мөнгөн гуйвуулга	1,037.1	919.4	816.7	220.4	-	1,037.1	-	220.4	-

2023 оны I улирлын байдлаар нэр бүхий 18 ББСБ 48.8 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс нэр бүхий 7 ББСБ 4.8 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 7. Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	Дүн	Эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХК
Нийт	48,812.7	100.0	36,620.9	32,853.8	15,958.9	48,812.7	690.7
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	4,832.0	9.9	4,708.8	2,930.2	1,901.8	4,832.0	690.7


Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс 70.5 хувиар буурсан.

Хүснэгт 8. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 2019.I–2023.I /мянган төгрөгөөр/

Өглөг	2019-I	2020-I	2021-I	2022-I	2023-I
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	2,545,088.9	6,178,955.0	3,753,541.3	16,370,513.9	4,832,041.5

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийг сүүлийн 5 жилийн I улирлуудын байдлаар зургаар харуулбал:

Зураг 11. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг /сая төгрөгөөр/



Нийт өр төлбөр ба эздийн өмч болон Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн хооронд ач холбогдол бүхий шугаман хамаарал бий эсэх шугаман хамаарлыг шинжлэв.



Үүний тулд сүүлийн 3 жилийн I улирал бүрд мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй байсан 4 ББСБ-ын тоон үзүүлэлтэд тооцоолол хийсэн.



Ингэхдээ тэгш өнцөгт координатын хавтгайн хэвтээ тэнхлэгт нийт өр ба эздийн өмч, босоо тэнхлэгт мөнгөн гуйвуулгын үйлчилгээний

өглөг тоог авав. Нэг цэг бүр нь нэг оны I улирлыг илэрхийлнэ. Үр дүнг тархалтын диаграммаар дор харуулав.

Зураг 12. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг ба Нийт өр төлбөр ба эздийн өмчийн хамаарал



Нэг хувьсагчийн утга өөрчлөгдөхөд нөгөө хувьсагчийн утга дагаад өөрчлөгдөж байгаа эсэх өөрөөр хэлбэл хувьсагчууд хоорондоо тодорхой харьцаатайгаар харилцан бие биедээ нөлөөлж байгаа эсэхийг тайлант жилийн I улирлын

Нийт өр төлбөр ба эздийн өмч болон Мөнгөн гуйвуулга үйлчилгээний өглөг хоорондын хамаарлыг тооцож зураглаж үзвэл сөрөг буюу бага хамааралтай нь харагдаж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9. Корреляцийн шинжилгээ

	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	Нийт өр төлбөр ба эздийн өмч
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	1	
Нийт өр төлбөр ба эздийн өмч	0.313707462	1

Санхүүгийн зохицуулах хороо нь улирал бүр ББСБ-уудаас ирүүлсэн зохистой харьцааны тайлан мэдээнд зайны хяналт тавьж шаардлагатай бол тайлангийн хариу, Улсын байцаагчийн албан шаардлагаар илэрсэн зөрчил дутагдалд хугацаатай үүрэг даалгавар өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй бол үйл ажиллагааг түдгэлзүүлэх хүчингүй болгох, торгуулийн арга хэмжээ авах ба гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл харьяаллын дагуу харьяа байгууллагаар шалгуулахаар шилжүүлдэг байна.


Санхүүгийн зохицуулах хороо 2021 онд 36 ББСБ-аас 2-т, 2022 онд 37 ББСБ-аас 14-т итгэлцлийн үйлчилгээ, төслийн зээлийн санхүүжилт, өрийн бичиг, эх үүсвэр болон валют арилжаа, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн хэрэгжилтэд хэсэгчилсэн газар дээрх хяналт шалгалтыг гүйцэтгэсэн. Харин ББСБ-дын мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд тусгайлсан хяналт шалгалт хийгдээгүй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны Мөнгө угаахтай тэмцэх албанаас хагас жил тутам

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ыг ББСБ-аар өөрсдөөр нь бөглүүлж түүнд нь эрсдэлийн үнэлгээ хийдэг. Тус эрсдэлийн үнэлгээгээр 2022 оны жилийн эцсийн байдлаар цахим төлбөр тооцоо, мөнгөн

гуйвуулгын үйлчилгээ эрхлэх 40 ББСБ-ын 32 буюу 82.5 хувь нь бага эрсдэлтэй, 4 буюу 10 хувь нь маш бага эрсдэлтэй гэж үнэлүүлснээс харвал Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт амжилттай мөрдөгдөж байна гэж үзэхээр байна.

Зураг 13. МУТС эрсдэлийн үнэлгээний түвшин



2022 онд Санхүүгийн зохицуулах хороонд ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой иргэд, аж ахуйн нэгжээс нийт 99 өргөдөл гомдол ирснээс мөнгөн гуйвуулгатай холбоотой 1 өргөдөл байгаа нь гадаадаас шилжүүлсэн мөнгийг еврогоор авах хүсэлт байв.

Мөн Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuukh.mn сайтад анхан шатны шүүхийн хүчинтэй шийтгэх тогтоолуудыг шүүж үзэхэд Эрүүгийн хуулийн

хуулийн 26.1 “Кибер орчинд хууль бусаар халдах”, 26.2 “Кибер орчинд хууль бусаар халдах, программ хангамж, техник хэрэгсэл бүтээх, бэлтгэх, борлуулах, ашиглах, тараах” зүйлээр зүйлчилж шийдвэрлэсэн нийт 20 шүүхийн шийдвэрийг нээлттэй байршуулснаас 18 нь Эрүүгийн хуулийн 26.1-д заасан гэмт хэргийг хулгайлах, цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэрэгтэй давхар зүйлчилж шийтгэсэн байна.

Харин цахим мөнгөн гуйвуулгатай холбоотой гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.



4.3. МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТАД МӨРДӨЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

Санхүүгийн зохицуулах хороо 2002 онд батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу ББСБ болон санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй бусад банк бус хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, цуцлах бүрэн эрхтэй.

Хуулийн дагуу төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй ББСБ-ууд хоёр тусгай зөвшөөрлийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос давхардуулж авах шаардлагатай болсон тул 2021 онд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа, холбооны зохицуулах хороо (ХХЗХ) банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид тусгай зөвшөөрөл олгох чиг үүргийг хэрхэн хуваарилахыг тодорхой тусгасан хамтран санамж бичиг байгуулсан.

Монгол Улсын хууль тогтоомжид цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн тогтолцоо бүрдсэн гэж үзэж болно. Үүнд:

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль²¹ – 2017 онд батлагдсан Үндэсний төлбөрийн системийн тухай хууль нь Монгол Улсын төлбөр тооцооны тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Энэхүү хууль нь цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ-дад хамаарах бөгөөд Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авсан байх ёстой.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль²² – 2002 онд батлагдсан. Тус хуулиар Банк бус санхүүгийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон

тусгай зөвшөөрлийн дагуу Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд эрхлэх бөгөөд мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6–д “цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ...”–г банк бус санхүүгийн үйл ажиллагаанд хамааруулахаар хуульчлагдсан.

Хуулийн 4–р зүйлийн 4.1.5 “цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ” гэж бусдын мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернэт, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог нь гүйцэтгэх ажиллагааг; гэж зааснаар цахим төлбөр тооцооны үйлчилгээ болж байдаг бөгөөд энэхүү заалтаар “банк бус санхүүгийн байгууллага нь төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа” зэрэг үйл ажиллагааг эрхэлж болох ба энэ үйл ажиллагаатай холбогдсон төлбөр тооцоог банкаар зуучлуулж банк хоорондын төлбөр тооцоонд шууд бус оролцогчийн үүрэг гүйцэтгэхээр тусгагдсан.

Энэ хууль нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулсан. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар Санхүүгийн зохицуулах хороо нь банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага байхаар тодорхойлсон.

²¹ <https://legalinfo.mn/mn/detail/12668>

²² <https://legalinfo.mn/mn/detail/103>

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль²³ – мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эрх зүйн үндсийг тогтоож өгсөн.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль²⁴ – эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдэд үзүүлэх мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан.

Кибер аюулгүй байдлын тухай хууль²⁵ – кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Цахим гарын үсгийн тухай хууль²⁶ – цахим орчинд хүн, хуулийн этгээд цахим гарын үсэг хэрэглэхийг зохицуулна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль²⁷ – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ нь хэрэглэгчийн мэдээллийг зөвшөөрөлгүй нэвтрэх, ашиглах, задруулахаас хамгаалах, мэдээл цуглуулах, ашиглах, хадгалах нөхцөл шаардлагыг мөрдөнө.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль²⁸ – Хэрэглэгчдийг хууран мэхлэх арилжаатай холбоотой үйлдлээс хамгаалах, хохирлыг нөхөн төлж барагдуулах зохицуулал тусгасан.

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй

этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам²⁹ – Энэ журамд цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ–дад тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг тусгасан. Уг журмын дагуу Банкнаас бусад цахим мөнгө гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөгөөс доошгүй байх ёстой бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг зохицуулалтыг дагаж мөрдөх ёстой.

Цахим мөнгөний журам³⁰ – Монголбанкнаас гаргасан уг журамд цахим мөнгөний үйлчилгээ, үйлчилгээ эрхлэгчдэд тавих шаардлагыг тусгасан. Уг журамд ББСБ–аас хураамж, хураамж, валютын ханшийн талаар тодорхой, ил тод мэдээлэл өгөх, харилцагчийн маргааныг шийдвэрлэхэд чиглэсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журамтай байхыг шаарддаг.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам³¹ – Монголбанк төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ–дад мөрдөх мөнгөн гуйвуулгад тавигдах шаардлагуудыг тодорхойлсон. ББСБ–аас харилцагчийн нягтлан шалгах, сэжигтэй гүйлгээнд хяналт тавих, сэжигтэй гүйлгээг холбогдох байгууллагад мэдээлэхийг шаарддаг.

Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам – энэ журам нь үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, хөрөнгө хуримтлуулах,

²³ <https://legalinfo.mn/mn/detail/9242>

²⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230554816671>

²⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390365491061>

²⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390355252531>

²⁷ <http://www.frc.mn/resource/frc/Document/2023/02/01/y079>

²⁸ <https://legalinfo.mn/mn/detail/551>

²⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231238887911>

³⁰ <https://old.legalinfo.mn/annex/details/8386?lawId=13302>

³¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14078>



гэмт хэргийг санхүүжүүлэх зэрэг хууль бус үйлдэлд ашиглахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн.

Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги³² нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Уг стратеги нь үндэсний төлбөрийн системийн оролцогч талуудын хамтын ажиллагаа, эрсдэлийг удирдах, ил тод байдлыг хангах, зохистой засаглалыг хэрэгжүүл, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам болон холбогдох яам, төлбөрийн системийн үйлчилгээ үзүүлэгчид болон системийн операторууд хоорондын өмчлөл, хариуцлагыг бий болгох зэргийг онцгойлсон.

ДҮГНЭЛТ

Дүгнэж хэлэхэд, ББСБ-аас үзүүлж буй хувь хүн, аж ахуйн нэгжээс нөгөөд мөнгө шилжүүлэх цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ дэлхий даяар улам бүр түгээмэл болж, мөнгө шилжүүлэх ажлыг хялбар, зардал бага, хурдан гүйцэтгэх боломжтой болж байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.22-т “мөнгөн гуйвуулга” гэж төлбөр шилжүүлэгч, төлбөр хүлээн авагчийн нэр дээр данс үүсгэлгүйгээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх Монголбанкны зөвшөөрөлтэй эрхлэх үйлчилгээг;³³ гэж тодорхойлсноор төлбөр шилжүүлэгч, төлбөр хүлээн авагчийн нэр дээр данс үүсгэлгүйгээр төлбөрийн үйлчилгээ хийгддэг тул бусад санхүүгийн үйл ажиллагаанаас ялгаатай.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ нь улс орон бүрд харилцан адилгүй эрх зүйн зохицуулалттай ч нийтлэг цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан, харилцагчаа таньж мэдэх, мөнгө угаахтай тэмцэх журам, хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, мэдээлэл хамгаалах хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

Эдгээр хууль тогтоомжийг дагаж мөрдөх нь хүндрэлтэй байж болох ч ББСБ-ууд харилцагчидтайгаа итгэлцлийг бий болгох, хурдацтай хөгжиж буй цахим мөнгөн гуйвуулгын салбарт өрсөлдөх давуу талыг хадгалах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, эрсдэлээс урьдчилсан сэргийлэх зэрэг нэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

Харин зохицуулагч байгууллагуудын хувьд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажуулснаар цахим мөнгөн гуйвуулгын салбарын тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааг аюулгүй, ил тод болгох, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зэрэгт чухал үүрэг гүйцэтгэдэг.

³² <https://legalinfo.mn/mn/detail/12668>

³³ <https://legalinfo.mn/mn/detail/12668>

Энэхүү судалгаанд ББСБ–ын хувьд цахим мөнгөн гуйвуулгын эрх зүйн зохицуулалт, зохицуулагч байгууллага, үүссэн асуудал түүний шийдвэрлэлт зэрэг хөндсөн болно.

Судалгаа маань ББСБ–ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж түүхийн товч, мөнгөн гуйвуулгын урсгал, зардал эхэлсэн. Дараа нь Дэлхийн банк, ОУВС, ФАТФ зэрэг олон улсын байгууллагуудаас мөнгөн гуйвуулгын эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж буй эрх зүйн акт, түүний онцлог, хяналт зохицуулалтыг судлав. Мөн ББСБ–ын хэвийн үйл ажиллагааг хангах зохистой харьцааны үзүүлэлтийг дурдлаа.

Үүний дараа АНУ, Энэтхэг, Филиппин, Их Британи, Мексик, Монгол зэрэг улс орнуудын цахим мөнгөн гуйвуулгын эрх зүйн зохицуулалт, зөрчил шийдвэрлэлтийн талаар тусгасан.

Дээр сонгон судалсан улс орнуудад цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ–уудын харилцааг зохицуулах тогтолцоо нь өөр өөр байдаг ч нийтлэг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг зохицуулалт, хэрэглэгчийн эрхийг болон мэдээлэл хамгаалах зэрэг зохицуулалтууд нь ижил төстэй байна.

Цахим мөнгөн гуйвуулгатай хууль тогтоомж зөрчсөн нийтлэг асуудалд залилан, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх орно. ББСБ–ууд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөж, хууль эрх зүйн орчинд гарсан өөрчлөлтийг цаг тухайд нь хэрэгжүүлэх нь цаг үетэйгээ зэрэгцэн амжилттай үйл ажиллагаа явуулж, харилцагчдынхаа мөнгөн хөрөнгийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой хэрэв хууль тогтоомж зөрчих юм бол өндөр торгууль, хариуцлагын шийтгэл хатуу байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ улам бүр дэлгэрэх өнөө үед зохицуулагч байгууллагын зүгээс тус үйлчилгээ үзүүлэгч ББСБ–д хийх хяналт, зохицуулалтыг эрчимжүүлэх, ББСБ–уудыг эрхлэх үйл ажиллагаанаас нь хамааруулж үйл ажиллагаанд тавих зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ялгаатай тооцох, бодит цагийн горимын хяналтыг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Мөн мөнгөн гуйвуулгын шимтгэл хураамжийн талаарх мэдээллийг тогтмол цуглуулж мэдээллийн сан үүсгэх, олон нийтэд ил тод мэдээлэх мөн Санхүүгийн зохицуулах хороо сар бүр зохицуулалттай этгээдээс хүлээн авдаг цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тайлан³⁴–д тусгасан мэдээллийн цар хүрээг өргөтгөх саналтай байна.

Түүнчлэн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг өндөр болон жил дараалан өглөгтэй тайлагнасан ББСБ–уудад төлөвлөгөөт хэсэгчилсэн газар дээрх шалгалтад хамруулж шалтгааныг тодруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байгаа эсэх болон зайнаас гүйцэтгэсэн эрсдэлийн үнэлгээг баталгаажуулж болно.

³⁴ <http://www.frc.mn/p/469>



ЭХ ҮҮСВЭР

- Банкны тухай хууль; Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль; Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль; Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль; Үндэсний төлбөрийн системийн тухай хууль; Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, холбоос: <https://legalinfo.mn>
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам; Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам; Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам; Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам; Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам, холбоос: <https://legalinfo.mn/>
- Цахим мөнгөний журам , холбоос: <https://old.legalinfo.mn/annex/details/8386?lawid=13302>
- Монгол Улсын хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ тайлан, 2018 он
- Монгол Улсын гадаад секторын тойм 2023 он 1 дүгээр улирал
- Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг 2022–2026 онд хөгжүүлэх стратеги
- <https://www.mglbar.mn/a/4597>
- <https://www.skyquestt.com/report/digital-remittance-market>
- Deloitte, “Digital Remittances: A New Era of Growth for Non-Bank Financial Institutions,” 2019
- Asian Development Bank, “Digital Financial Services for Remittances: The Role of Non-Bank Financial Institutions,” 2020
- World Bank Group, “Digital Financial Services for Remittances: Opportunities and Challenges for Non-Bank Financial Institutions,” 2019,
- International Finance Corporation, “Digital Financial Services for Remittances: A Guide for Non-Bank Financial Institutions,” 2019,
- Financial Action Task Force (FATF). (2019). Guidance for a risk-based approach to virtual assets and virtual asset service providers.
- International Organization for Migration (IOM). (2019). Regulatory challenges facing the remittance industry: A global perspective. Retrieved from
- World Bank. (2019). Remittance prices worldwide
- <https://www.worldbank.org/en/news/press-release/2023/06/13/remittances-remain-resilient-likely-to-slow>
- https://www.1212.mn/mn/statistic/statcate/573087/table-view/DT_NS0_0100_001V10
- <http://hmc.mn/medee/v/6>

ХАВСРАЛТ 1.

**ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО, МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН³⁵**

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

Д/д	Валютын төрөл	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ /тайлант үеэр/						Хувь
		Шилжүүлсэн			Хүлээн авч олгосон			
		Валютын дүн	Гүйлгээний тоо	Төгрөгт хөрвүүлсэн дүн	Валютын дүн	Гүйлгээний тоо	Төгрөгт хөрвүүлсэн дүн	
1	USD							#DIV/0!
2	EUR							#DIV/0!
3	JPY							#DIV/0!
4	CHF							#DIV/0!
5	GBP							#DIV/0!
6	CNY							#DIV/0!
7	RUB							#DIV/0!
8	KRW							#DIV/0!
9	Бусад валют							#DIV/0!
НИЙТ		-	0	-	-	0	-	
							Хамгийн их	#DIV/0!

ТАМГА

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/

ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

³⁵ <http://www.frc.mn/p/469>